

## XX Зууны сүүл үеийн Монгол Халимагийн харилцаа

Н.Наранжаргал<sup>1\*</sup>

*Товч агуулга:* Энэхүү өгүүлэлд Монгол-Халимагийн XX зууны сүүл үеийн харилцааны өрнөл хөгжлийг улс төр, шинжлэх ухаан, соёл, хөдөө аж ахуйн харилцаа хамтын ажиллагааны жишиг дээр хураангуйлан авч үзээд нэгтгэн дүгэх оролдлого хийсэн болно

*Abstract:* This paper considered about the relationship between Mongolia and Kalmykia in the end of the XX century. During that time, Mongolia and Kalmykia had supported the traditional relationship set during the socialist time and cooperated actively on exchanging high level representatives, making official visits, and making agreements. Kalmykia had intended to cooperate on the fields of politics, science and culture while Mongolia had had a strong interest on collaboration of agriculture and economy.

*Түлхүүр үг:* Монгол улс, Халимаг улс, харилцан айлчлал, гэрээ, хэлэлцээр, хамтын ажиллагаа, ашиг сонирхол.

\* \* \*

1980-аад оны сүүлээр ЗХУ-д өөрчлөн байгуулалт эхэлж, социализм задран унаснаар түүний бүрэлдэхүүнд байсан олон улс орнууд тусгаар тогтнолоо олж авсан билээ. Энэхүү улс төрийн үйл явцыг Халимагийн удирдагчид өөрсдөдөө ашигтайгаар эргүүлэхийг эрмэлзэж байв. Энэ хүрээнд 1990 оны 12-р сараас ЗСБНАвт Халимаг улсын нэрийг ЗСБНХалимаг улс болгон өөрчилж, 1992 оны 3-р сарын 31-нд ОХУ-ын бүрэлдэхүүнд Бүгд Найрамдах Халимаг Улс (БНХАУ)-ыг байгуулсан юм. 1993 оны 4-р сарын 11-нд Халимагийн анхны ерөнхийлөгчөөр К.Н.Илюмжинов сонгогдож, 1993 оны 4 сарын 12-ноос Халимаг улс

1. \*Норовсамбуугийн Наранжаргал- Халимагийн Улсын Их Сургуулийн Түүхийн салбарын докторант

Ерөнхийлөгчийн засаглалтай, бүгд найрамдах, өөртөө засах улсын статустай болсон ба 1994 оны 4 сарын 5-нд Халимаг улс өөрийн шинэ үндсэн хуулиа баталсан байна<sup>2</sup>.

Ийнхүү Халимаг улс тодорхой хэмжээгээр тусгаар улсын байдалтай болсноор өөрийн гэсэн бие даасан бодлогууд явуулж эхэлжээ. Тухайлбал, тэд угсаа гарал нэгтэй Монгол улс, сарт халимагууд амьдардаг Киргизстан улстай харилцаж эхэлсэн байна.

Халимагийн зүгээс Монгол улстай харилцах явдалд маш их анхаарч байсан бөгөөд хоёр улсын удирдагчдын анхны уулзалт 1990 оны 5-р сарын 15-нд БНМАУ-ын Ерөнхийлөгч П.Очирбат ЗСБНХУ-д айлчлах үеэр Москвад болсон байна<sup>3</sup>. Энэхүү уулзалтанд Монголын талаас Ерөнхийлөгч П.Очирбат, ГЯЯ-ны сайд Ц.Гомбосүрэн, Элчин сайд Ц.Гүрбадам, АИХ-ын Тэргүүлэгчдийн даргын туслах Р.Батаа, Элчин сайдын яамны элчин зөвлөх Ж.Энхсайхан; Халимагийн талаас ЗСБН Автономит Халимаг улсын дээд зөвлөлийн дарга В.М.Басанов, ЗМНН-ийн Халимагийн салбарын хариуцлагатай нарийн бичгийн дарга В.З.Церенов нар оролцсон ажээ. Энэ уулзалтаар Халимагийн тал Монголын талд дараах санал тавьсан байдаг. Үүнд:

- 1974 оноос хойш хоёр улсын хооронд тогтсон харилцааг цаашид хөгжүүлэх,
- Элистад одоо Монголын 14 оюутан суралцаж байгаа бөгөөд цаашид үргэжлүүлэн жил бүр 15-20 оюутан авах боломжтой, гэхдээ Элиста хот нь Москва, Ленинград шиг нөхцөлтэй бишийг анхаарах хэрэгтэй
- Хэл, соёл, түүх судлах зорилгоор 3-5 халимаг оюутныг Монголд сургах сонирхолтой бөгөөд энэ асуудлыг ЗХУ-ын Дээд боловсролын улсын хороогоор дамжуулахгүйгээр солилцооны шугамаар явуулах
- Халимаг улсын хэмжээнд гэр байхгүй тул Өвөрхангай аймгаас 220 гэр худалдан авах хүсэлт тавиад байгаа бөгөөд үүнд дэмжлэг үзүүлэх

2. История калмыкии с древнейших времен до наших дней. В трех томах. Элиста. 2009.

3. ГХЯ-ны архив. Хө №-2, Д№-2, хн-678, хуудас 1

- БНМАУ болон Автономит Халимагийн хооронд шууд харилцаа тогтоох
- Монгол улсын Соёлын яамтай харилцах харилцаагаа хөгжүүлж, Монголын ШУА-тай монгол судлалын талаар хамтран ажиллах
- Сүлжмэл болон оёдлын үйлдвэрийн бүтээгдэхүүн болон арьс боловсруулах үйлдвэртэй хамтран ажиллах
- Соёл урлагийн харилцааг амжилттай хөгжүүлэхийн зэрэгцээ материаллаг салбарт хамтын ажиллагааг идэвхжүүлэх, үүний тулд урлагийн баг илгээхээр асуудал багтаж байв.
- Харин БНМАУ-ын талаас
- ХАА-н салбарт хамтран ажиллах,
- Үндэсний дээл, гутал, малгай зэргийг нийлүүлэх зэрэг саналуудыг тавьсан байна.

Энэ үед Монголын тал Халимагтай эдийн засгийн талаар хамтран ажиллах сонирхолтой байсан бол Халимагийн тал Шинжлэх ухаан, соёлын салбарт хамтарч ажиллах талаар түлхүү анхаарч, санал тавьж байлаа. Тэрчлэн хэдэн хоногийн дараа болох “Жангар”-ын 550, МНТ-ны ойд Монголын төр засгийн удирдагчдыг урьсанаар уулзалт дууссанаж.

1990 оны 6-р сард Монголын Үндэсний Филармоны захирал Д.Ухнаа Чингис хаан хамтлагийг дагуулан очиж, Элиста хот болон Их буурал, Тройцкт зэрэг хөдөө тосгонуудад тоглолт хийсний<sup>4</sup> зэрэгцээ Увс аймгийн хөгжимт драмын театрын уран бүтээлчид мөн айлчлан тоглолт хийсэн нь<sup>5</sup> Монгол, Халимагийн харилцаанд чухал тэмдэглэлтэй үйл явдал болжээ. Халимаг түмэн тийнхүү өөрчлөлт шинэчлэлтийн шинэ үеийн эхэнд элгэн садан түмнийхээ соёл урлагтай илүү түлхүү танилцсан нь хоёр тал харилцаандаа хэр анхаарч байсны илэрхийлэл юм.

4. “Халимаг үнэн” сонины 1991 оны туулай сарын 23 дугаар. - Амарсанааны нэрэмжит Халимагийн ҮТНС.

5. Халимаг үнэн сонины 1990 оны хонь сарын 17. Мөн тэнд.

1990 оны 9-р сард Халимагт болсон “Жангарын 550” жилийн ойд Монголоос очсон төлөөлөгчдийг Соёлын сайд Б.Балжинням толгойлж, бүрэлдэхүүнд жүжигчин Н.Сувдаа, дуу бүжгийн чуулгын дуучин Т.Баяраа, хөгжимчин И.Цогбадрах, “Түмэн эх” чуулгын дуучин М.Алтангэрэл нар орсон бөгөөд тэд “Жангарын” баярын хөтөлбөрт өөрсдийн тоглолыг оруулан толилуулсан байна. Мөн тэд Халимагийн ард түмэнд “Мандухай цэцэн хатан” киног үзүүлсэн ажээ<sup>6</sup>. Тэрчлэн эрдэм шинжилгээний хурал болж, эрдэмтэн А.Лувсандэндэв хуралд оролцон “Тод үсгийн учрыг шинжлэх нь” сэдэвтэй илтгэл хэлэлцүүлсэн байна. Уг баярын үйл ажиллагаанд Өвөрхангай аймгийн төлөөлөгчид болон академич Ш.Бира, С.Норовсамбуу, ЗХУ дахь Монголын элчин зөвлөх Ж.Энхсайхан нар мөн оролцжээ. Өвөрхангай аймгийн хөгжимт драмын театрын уран бүтээлчид Халимагийн Элиста хот болон бусад районуудад тоглолт хийсэн байна.

1990 оны 12-р сарын 20-ны өдөр ЗХУ-д сууж байсан Монголын элчин сайд Н.Мишигдорж Халимагт айлчлахад ЗСБНХалимаг Улсын Дээд зөвлөлийн дарга В.М.Басанов уулзаж, Халимагийн тал монгол хэл, соёл, утга зохиол, анагаах ухаан, ардын гар урлаг гэх мэт мэргэжлээр оюутан, сурагч сургаж авах, оронд нь монголоос жил бүр 25-30 оюутныг суралцуулж болох санал хүсэлт тавьжээ<sup>7</sup>. Мөн тэрээр 1991 оны 3-4 сард Монгол улсад албан ёсны айлчлал хийж, цаашид соёл, шинжлэх ухааны салбарт хамтын ажиллагаа хөгжүүлэх асуудлаар санал солилцох хүсэлт гаргасан байна<sup>8</sup>. Энэ хүсэлтийн дагуу 1991 оны 3-р сарын 9-нд БНМАУ-ын Дэд ерөнхийлөгч, УБХ-ын дарга Р.Гончигдорж ЗСБНХалимаг Улсын Дээд зөвлөлийн дарга В.М.Басановыг 4-р сарын эхний хагаст БНМАУ-д айлчлан ирэхийг албан ёсоор урьжээ.

Энэ дагуу 1991 оны 4-р сарын 9-13-ны хооронд ЗСБНХалимаг улсын Дээд Зөвлөлийн дарга Басанов Владимир Манцынович, ЗСБНХалимаг Улсын СнЗ-ийн дарга Михайлов Батыр Чимидович, ЗСБНХалимаг улсын дээд зөвлөлийн хууль боловсруулах хорооны

6. Халимаг үнэн сонин 1990 оны нохой сарын 23 дугаар. №160. Мөн тэнд.

7. ГХЯ-ны архив. Хө №2, Д№-2, хн-678, хуудас 1

8. ГХЯ-ны архив. Хө №2, хн-592, хуудас 58

дарга Сергеев Вениамин Санжиевич, ЗСБНХалимаг улсын дээд зөвлөлийн экологийн асуудал эрхэлсэн хорооны дарга, Халимаг улсын их сургуулийн ректор Борликов Герман Манджиевич, Зөвлөлтийн монгол судлалын холбооны эрдэмтэн нарийн бичгийн дарга Церенов Василий Зулкаевич нарын бүрэлдэхүүнтэй төрийн төлөөлөгчид БНМАУ-д айлчилжээ. Энэхүү айлчлал нь Халимагийн төлөөлөгчдийн хувьд гадаадын оронд бие даан хийж буй анхны айлчлал байснаараа онцлог байлаа.

Халимаг улсын Төлөөлөгчид БНМАУ-ын Ерөнхийлөгч П.Очирбат, Дэд Ерөнхийлөгч, УБХ-ын дарга Р.Гончигдорж, АИХ-ын дарга Ж.Гомбожав, Монголын парламентын бүлгэмийн гүйцэтгэх хорооны дарга С.Зориг, БНМАУ-ын бага хурлын орлогч дарга К.Зардыхан, Байнгын хорооны дарга С.Баяр, Л.Цог, Т.Очирхүү, М.Энхсайхан, Р.Хатанбаатар нартай уулзаж ярилцсан байна. Төлөөлөгчид МУИС, ШУА, Соёл, урлагын хөгжлийн хороонд ажил хэрэгч уулзалтууд хийж, Улсын төв музей, Гандантэгчинлэн хийдийг үзэж сонирхон, Савхин эдлэлийн үйлдвэр, “Говь” компаний үйл ажиллагаатай танилцжээ. Төлөөлөгчид айлчлалд өндөр ач холбогдол өгч, гарал, үүсэл нэгтэй ах дүү ард түмэнтэйгээ эртний уламжлалт харилцаа холбоогоо бэхжүүлэх нь халимагийн ард түмэн, хэл соёл, зан заншлаа сэргээн хөгжүүлэхэд, Монгол, Зөвлөлтийн найрамдалт харилцааг бэхжүүлэхэд тодорхой хувь нэмэр болно хэмээн үзэж, энэ нь өнөө үед өрнөж буй өөрчлөн байгуулалт, ардчиллын-үр дүн хэмээн онцлон тэмдэглэж байв.

Төлөөлөгчид Улаанбаатараас гадна Өвөрхангай аймагт айлчлан АДХГЗ-ны удирдлагуудтай уулзан, Тарагт сумын малчин Лувсанцэрэнгийнд зочилж, хөдөө нутагт өрнөж буй өөрчлөлт шинэчлэлтэй танилцжээ. ЗСБНХалимаг улсын Дээд зөвлөлийн дарга В.М.Басанов БНМАУ-ын Ерөнхийлөгч П.Очирбат, Дэд ерөнхийлөгч, УБХ-ын дарга Р.Гончигдорж, Засгийн газрын ерөнхий сайд Д.Бямбасүрэн нарыг Халимагт айлчлахыг албан ёсоор урьж, урилгыг гардуулав.

1991 оны 4-р сарын 12-нд Монгол, Халимагийн хоорондын соёл, хамтын ажиллагааны гэрээ, эдийн засгийн хамтын ажилгааны тунхаглал, парламентуудын харилцаа холбооны протокол, Монгол, Халимагийн

Их сургуулиудын хоорондын шууд харилцааны төлөвлөгөөнд гарын үсэг зурсан байна. Парламентын протоколд Монголын талаас УБХ-ын байнгын хорооны дарга С.Баяр, Халимагийн талаас Дээд зөвлөлийн байнгын хорооны дарга Г.М.Сергеев нар гарын үсэг зуржээ<sup>9</sup>.

1991 оны 4-р сарын сүүлээр Монголын оюутны нийгэмлэгийн тэргүүн Ж.Баяраа 17 хүний бүрэлдэхүүнтэй Халимагт айлчлав<sup>10</sup>. Энэ үед БНМАУ-ын Засгийн газар оюутан харилцан солилцох талаар Халимагийн талаас удаа дараа тавьсан хүсэлтийг авч хэлэлцээд, Монгол улсаас Халимагт оюутан сургах шаардлагагүй бөгөөд харин хоёр улсын хамтын ажиллагааг өргөтгөн хөгжүүлэх үүднээс 1991 оны хичээлийн жилээс эхлэн 1995 он хүртэл жил бүр 5 оюутныг БНМАУ-ын зардлаар хүссэн мэрэгжлийнх нь дагуу их, дээд сургуульд суралцуулах тогтоол гарсан байна.

1990 онд Монголд зохиогдсон Монгол туургатны оюутны анхдугаар фестивалд Халимагаас 26 оюутан ирж оролцжээ<sup>11</sup>.

1991 оны 7-р сарын 9-нд Халимагийн Сайд нарын зөвлөлийн дарга Б.Ч.Михайлов БНМАУ-ын Ерөнхий сайд Д.Бямбасүрэнгийн нэр дээр Монгол, Халимагийн хооронд соёл, боловсрол, шинжлэх ухаан, эрүүлийг хамгаалах болон эдийн засаг, барилгын салбарт 1991-1995 онд хамтран ажиллах тухай хөтөлбөр бэлтгэн ирүүлсэнийг БНМАУ-ын Гадаад хэргийн яам 8-р сарын 2-ны өдөр хүлээн аваад Засгийн газартаа мэдэгдэв. Засгийн газар 10-р сарын 23 хүртэл Боловсролын яам, Радио телевизийн газар, Эрүүлийг хамгаалах, Нийгэм хангамжийн яам, ХААЯ, Засгийн газрын дэргэдэх барилга, хот байгуулалтын комисс зэрэг газруудад уг хөтөлбөрийн төсөл дээр саналыг нь авч, төслийг шинэчлэн боловсруулсан байна. Энэхүү шинэчлэн найруулсан хөтөлбөрийг 1992 оны 3-р сарын 2-нд элчин сайд Н.Мишигдоржид хүргүүлсэн ба 3-р сарын 6-ны өдөр Ерөнхий сайд Д.Бямбасүрэн болон Халимаг улсын Сайд нарын зөвлөлийн дарга Б.Ч.Михайлов нар уг хөтөлбөрт гарын үсэг зурж баталжээ. Хөтөлбөр батлагдсаны дараа 1992 оны 3-р сарын 27-нд Засгийн газар Соёл урлагийн хөгжлийн хорооны

9. КАССР. Архив. Ф№Р-309. Он№ 1. Хр 2473.

10. Халимаг үнэн сонины 1990 оны Могай сарын 20. Амарсанааны нэрэмжит Халимагийн үндэсний төв номын сан.

11. Халимаг үнэн сонины 1991 оны Нохой сарын 17. Халимагийн үндэсний төв номын сан.

дарга Б.Бадар-Ууган, Радио, телевизийн дарга З.Алтай, “Жуулчин” нэгдлийн дарга Батсүх, Барилга хот байгуулалтын комиссын дарга Р.Шаваржаа, Үндэсний хөгжлийн сайд Ж.Батсуурь, ХААЯ-ны сайд Д.Раднаарагчаа, Хүнсний үйлдвэр худалдааны нэгтгэлийн ерөнхий захирал Г.Лхагваа, МУИС-ийн ректор П.Дорж, ШУА-ийн ерөнхийлөгч Д.Баатар, Боловсролын сайд Н.Уртнасан, Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа нар болон Монгол хэвлэл нэгдэл, ХААЯ-ны үржлийн компанид уг хөтөлбөрийг хүргүүлэн, өөрсдөд холбогдох заалтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг үүрэг болгосон байна.

1992 оны цагаан сараар БНХалимаг Улсын Дээд зөвлөлийн дарга В.М.Басанов монголын ард түмэн цагаан сарын мэндчилгээ ирүүлсэнд, БНМАУ-ын Дэд ерөнхийлөгч, УБХ-ын дарга Р.Гончигдорж 1992 оны 2-р сарын 1-нд хариу талархал дэвшүүлж, ирж буй жил хоёр ард түмэн, парламентын харилцаанд шинэ хөгжил дэвшил авч ирнэ хэмээн итгэж байгаагаа илэрхийлжээ.

1992 оны 2-р сарын 11-нд БНХалимаг Улсын Дээд зөвлөлийн даргаар И.Будаевыг сонгогдоход Монгол Улсын Их хурлын дарга Н.Багабанди баяр хүргэн амжилт хүссэн байна.

Монгол улс болон Халимагийн хооронд байгуулагдсан тэрхүү хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн эхний ажил бол Буриад, Халимаг, Монгол хүүхдийн нийгэмлэгээс санаачилсан Монгол туургатны хүүхдийн “Бага наадам”-ыг Улаанбаатар, Улаан-Үд, Элиста хотуудад хийх явдал байсан бөгөөд энэ тухай хэлэлцээр 1992 оны 10 сараас эхлэн тухайн улсуудын засгийн газар болон элчин сайдын яамны хүрээнд хийгдэж эхэлжээ. Уг ажилд Оросын ШУА-ийн ШУ, техник, Үйлдвэрлэлийн “Дидактик” төв зуучлагчаар ажилласан байна. Эхний ээлжинд уг наадамыг зохион явуулахад шаардагдах хөрөнгийг гурван улс тус бүр гурав, гурван сая төгрөг гарган Улаанбаатарт дундын сан байгуулах замаар шийдвэрлэхээр болжээ<sup>12</sup>.

1992 оны 5-р сард Элиста хотод болсон Монгол туургатны хүүхдийн “Алтанбулаг” наадамд Монгол, Буриад, Тува, Горный Алтай болон хөрш зэргэлдээх Дагестан, Ростов, Волгоградыг

12. ГХЯ-ны архив. Хө №2, Д№2, хн-678, хуудас 39

хүүхдүүдийн төлөөлөл ирж оролцсон байна<sup>13</sup>. Мөн энэ үеэр сансрын нисэгч Ж.Гүррагчаа болон Монгол-Халимагийн нийгэмлэгийн ахлагч М.Ганзориг нар Халимагт айлчилжээ<sup>14</sup>.

Халимагийн ерөнхийлөгчөөр сонгогдон 1993 оны 4-р сарын 23-нд үүрэгт ажилдаа орсон К.Н.Илюмжинов Халимаг, Монголын харилцааны талаар өмнөх засгийн газруудын үед хийгдсэн гэрээ хэрэлцээр, бодлогыг үргэлжлүүлэн ажилласан бөгөөд энэ тухайгаа ОХУ-ын ГЯЯ-ны Хэвлэлийн төвд 4-р сарын 28-ны өдөр хийсэн мэдэгдэлдээ цохон тэмдэглэжээ. Тэрээр, “Гадаад бодлого эрхэлсэн зөвлөхүүддээ Халимаг, Монголын хооронд байгуулах хамтын ажиллагааны хэлэлцээр боловсруулах үүрэг өгөөд байгаа. Бид уг үндэс нэгтэй билээ. Хоёр орны харилцааг улам хөгжүүлэх хэрэгтэй гэж бодож байна. Ойрын 2-3 сард би өөрөө Монголд айлчлах буюу Монголын Засгийн газрын төлөөлөгчдийг урина”<sup>15</sup> хэмээн мэдэгдсэн юм. Мөн тухайн үеийн нөхцөл байдлаас шалтгаалан 1993 онд хийхээр төлөвлөөд байсан Ойрад монголчуудын чуулга уулзалтыг дараа жил болгон хойшлуулсан<sup>16</sup> байдаг.

К.Н.Илюмжинов өөрийн бодлогоо ажил хэрэг болгох үүднээс 1993 оны 10-р сарын 5-нд Монголд суух БНХалимаг Улсын бүрэн эрхт төлөөлөгчөөр Ю.Н.Кручкиныг томилжээ. Тэрээр Монгол-Халимагийн харилцааны асуудлыг Москвагаас хариуцан ажиллаж байсан аж.

1994 онд Элиста хотод Монгол туургатны оюутны III фестивал болов. Анхдугаар фестиваль 1990 онд Монголд болсон бол II фестиваль 1992 онд Улаан-Үдэд болсон<sup>17</sup>. Мөн оны 2-р сарын 8-нд Монголын соёлын үзэсгэлэнг боловсролын доктор Доржпагма Элиста хотод гаргажээ.<sup>18</sup>

1994 оны 7-р сарын 8-12-нд Улаанбаатарт дэлхийн Монгол туургатан багачуудын их наадам болов. Энэ наадмыг Халимагийн

13. КАССР. Архив. Ф№ 309. Оп 1. Х2081.

14. Халимаг үнэн сонины 1990 оны Тахиа сарын 3. Амарсанааны нэрэмжит Халимагийн үндэсний төв номын сан.

15. ГХЯ-ны архив. Хө №-2, Д№-2, хн-678, хуудас 60

16. ГХЯ-ны архив. Хө №-2, Д№-2, хн-678, хуудас 58

17. Халимаг үнэн сонины 1994 оны Хонин сарын 26. Амарсанааны нэрэмжит Халимагийн үндэсний төв номын сан.

18. Халимаг үнэн сонины 1990 оны 2 сарын 8. Амарсанааны нэрэмжит Халимагийн үндэсний төв номын сан.



ерөнхийлөгч К.Н.Илюмжинов зохион байгуулсан байна. К.Н.Илюмжиновыг дагалдан түүний Монголыг хариуцсан зөвлөх Ю.Н.Кручкин, Гадаад эдийн засгийн асуудал хариуцсан зөвлөх Евгени Костюхин, Халимаг улсын соёлын департаментын дарга Н.Д.Санжиев нар<sup>19</sup> ирсэн билээ. Уг наадамд Халимагийн талаас 25 хүүхэд оролцсон нь тооны хувьд тухайн үедээ хамгийн өндөр үзүүлэлт төдийгүй энэ арга хэмжээ удам гарал нэгтэй монгол ахан дүүсийн хэлхээ холбоог бэхжүүлэхэд, нэн ялангуяа залуу хойч үеийнхэндээ монгол туургатнаа таниулах, ойртон нөхөрлөх, итгэлцэл ойлголцол буй болоход үлэмж ач тустай үйл явдал болсон билээ. К.Н.Илюмжиновыг Монголд байх хугацаанд нь Монгол Улсын Ерөнхийлөгч болон шашны тэргүүн нар хүлээн авч уулзаж, эдийн засгийн талаар хамтран ажиллах тухай яриа өрнүүлцгээжээ<sup>20</sup>. Энэ айлчлал нь хэдийгээр Халимагийн Ерөнхийлөгчийн албан ёсны бус айлчлал байсан ч Монголын тал түүнийг төрийн хэмжээнд хүлээн авсан юм.

Энэ үед хоёр улсын хооронд тогтоосон харилцааны хүрээнд Халимагууд соёлын харилцаа хөгжүүлэх явдалд ихээхэн анхаарал хандуулж, санал хүсэлт тавьж байсан тул Монголын тал Халимагийн соёлын коллежийн урилгын дагуу үндэсний хөгжмийн багшаар Чойжамцын Сампилноровыг 1990 онд, лимбийн багшаар Магсаржавын Бадам, ятгын багшаар Зундуйн Нарантуяа нарыг 1993 онд тус тус илгээж ажилуулсан байна.

Хоёр улсын засгийн газрын хооронд байгуулагдсан гэрээний дагуу Халимагийн талаас оюутан сургах тохиролцооны хүрээнд 1995-1996 оны хичээлийн жилд Улаанбаатар хотын Соёлын коллежийн лимбийн ангид Манджиев Надбит, морин хуурын ангид Бухаев Баатор, Эдняшев Дмитрий, хуучирын ангид Бурулова Саглара, Мухараева Юлия, Шургучиева Анастасия, ятгын ангид Бадмаева Кермен, Зердеева Елена нар суралцаж төгссөн ажээ.

1996-1997 онд Халимагийн соёлын яамны урилгаар хуучрын багш С.Цэвэлмаа, 1998 онд хөгжмийн сургуулийн урилгаар морин хуурын багш Ганбат, шанзын багш Отгон нар тус тус Халимагт

19. ГХЯ-ны архив. Хө №-2, Д№-2, хн-678, хуудас 57

20. Халимаг үгэн сонин 1990 оны 7 сарын 12. Амарсанааны нэрэмжит Халимагийн үндэсний төв номын сан.

очиж ажилласан байна. 1995 онд Монгол улсын цэргийн “Дайчин алдар” хамтлаг Халимаг улсад айлчлан тоглолт хийжээ. 1999 онд “Дайчин алдар” хамтлагийн урилгаар Халимагийн ахмадын “Эрдэм” ансамбль Монголд айлчлан тоглолтоо хийсэн юм. Энэ үед оюутан солилцооны асуудал жил ирэх бүр багассаар байсан бөгөөд 1998 онд Монголд 2 оюутан л сурацгааж байсан нь үүнийг илтгэнэ.

XX зууны төгсгөлд хоёр улсын харилцааны хүрээнд болсон нэг үйл явдал бол 1999 онд 9-р сарын 15-нд болсон Зая бандида Намхайжамцын мэндэлсний 400 жилийн ойд Монголын талаас элчин сайд А.Цолмон, 1-р нарийн бичгийн дарга Г.Өлзийсайхан нар оролцсон явдал байв. Энэ бүхэн Монгол, Халимаг хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны түүхэн хөгжилд зохих хувь нэмэр болсон гэж хэлж болно.

Тийхүү 1990-ээд оноос эрс идэвхжсэн хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд төрийн дээд түвшний харилцан айлчлал, монгол туургатны багачууд, оюутны наадам зэрэг олон үйл ажиллагаадаа дараалан зохион байгуулагдаж, Монголын тал Халимагийн оюутнуудыг монголд сургах, үндэсний хөгжмийн багш илгээх, дуу хөгжийн хамтлаг, ансамбль илгээх зэргээр хамтран ажиллаж, хоёр улсын харилцаанд багагүй амжилт олжээ. Гэсэн хэдий ч тухайн үед ОХУ болон Монгол улсад бий болсон эдийн засгийн хүндрэл, улс төрийн нөхцөл байдал зэргээс шалтгаалан хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа бүх талаар цэцэглэн хөгжиж чадалгүй, зогсонги байдалд орсон байна. Үүний улмаас нэг хэсэг төр улсын хэмжээнд гэхээсээ хувь хүмүүс, зарим нэг байгууллага хоорондын харилцаагаар хязгаарлагдах хэмжээнд хүрсэн гэж хэлж болно. Гэвч энэ нь түр зуурын, цаг хугацааны төдий зүйл байсан билээ.

XX зууны сүүл үеийн Монгол, Халимагийн харилцааг ерөнхийлөн дүгнэж үзэхэд, талууд социализмын үеийн уламжлалт харилцаагаа цаашид хөгжүүлэхийн хамт ажил хэргийн харилцаагаа тогтмолжуулах, төрийн дээд хэмжээний төлөөлөгчид харилцан солилцох, албан ёсны айлчлал хийх, гэрээ хэлэлцээр байгуулах зэргээр идэвхтэй хамтран ажиллах болсон байна. Энэ үед Халимагийн тал улс төр, шинжлэх ухаан, соёлын салбарт илүү түлхүү хамтран ажиллахыг чухалчилж байсан бол Монгол улсын хувьд ХАА, Эдийн засгийн салбарт хамтран

ажиллах сонирхол давамгайлж байжээ.

**Ашигласан материал**

1. ГХЯ-ны архив. Хө №-2, Д№-2, хн-678
2. ГХЯ-ны архив. Хө №-2, хн-592
3. КАССР. Архив. Ф№Р-309. Оп№ 1. хр 2473
4. КАССР. Архив. Ф№ 309. Оп № 1. хр 2081.
5. История калмыкии с древнейших времен до наших дней.  
В трех томах. Элиста. 2009.
6. Халимаг үнэн сонины 1990 оны Хонь сарын 17 дугаар.
7. Халимаг үнэн сонины 1990 оны Нохой сарын 23 дугаар.
8. Халимаг үнэн сонины 1990 оны Могай сарын 20 дугаар.
9. Халимаг үнэн сонины 1990 оны 2 сарын 8 дугаар.
10. Халимаг үнэн сонины 1990 оны 7 сарын 12 дугаар.
11. Халимаг үнэн сонины 1990 оны Тахиа сарын 3 дугаар.
12. Халимаг үнэн сонины 1991 оны Нохой сарын 17 дугаар.
13. Халимаг үнэн сонины 1991 оны туулай сарын 23 дугаар .
14. Халимаг үнэн сонины 1994 оны Хонин сарын 26 дугаар.